

15/4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Гүйцэтгэлийн аудитын баг

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН
АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖИД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:ХОА 2023/25 20-ШТА ГА

Орон нутагт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж
буй төсөл арга хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн
зохицуулалт байхгүйгээс үр дүнг тооцох боломжгүй байна.

Ховд хот
2023 оны 7 сар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Утас: 70432545 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn
Аудитор: Д.Балжинням
Утас: 7043-2545 Цахим хаяг: baljinnyamd @audit.gov.mn
Аудитор: Ц.Бадрал
Утас: 7043-2545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл	4
Ерөнхий зүйл	5
БҮЛЭГ 1. Аймгийн хэмжээнд салбарын зээл тусламжийн нэгдсэн мэдээлэл байхгүй байгаагаас хэрэгжилтийг бодиттой дүгнэх боломжгүй байна	6
А.1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байна	6
А.2. Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна	8
БҮЛЭГ 2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр хөдөө аж ахуйн салбараас орох орлого нэмэгдэж үр өгөөж бий болохоор байна.	10
Б.1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдсан байна.	10
Б.2 Малын эрүүл мэндийн төсөл хэрэгжсэнээр бэлчээрийн менежментийг сайжруулахад тодорхой ахиц гарч, төсөл үр дүнтэй хэрэгжиж, услалтын системийг сайжруулах төслүүд гүйцэтгэлийн шатандаа явагдаж байна.	11
БҮЛЭГ 3. Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.	12
В.1 Орон нутгийн эрх бүхий байгууллагууд зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй, төсөл хэрэгжүүлэгч нэгжээс хэрхэн хяналт хэрэгжүүлж байгаа нь тодорхойгүй байна.	12
В.2. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй зээл, тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож байна.	13
Ерөнхий дүгнэлт:	14
Зөвлөмж	14
Холбогдох байгууллагын санал	15
Саналд өгсөн тайлбар	15

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага

Хүснэгтийн товчлол

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хамаарах заалтуудын харьцуулалт	6
Хүснэгт 2	Ховд аймагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын зээлийн мэдээлэл	7
Хүснэгт 3	Ховд аймагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын зээлийн мэдээлэл	7
Хүснэгт 4	Ховд аймагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын зээлийн мэдээлэл	8
Хүснэгт 5	Батлан даалтын зээлийн мэдээлэл	9
Хүснэгт 6	Батлан даалтын зээлийн мэдээлэл	9

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө", Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

"Хөдөө аж ахуйн саларын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж"-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг даргын тамгын газар, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч холбогдох байгууллагуудын 2016-2022 оны хуулиар чиг үүрэг хүлээсэн байгууллагуудын мэдээ, тайлан, судалгааг хянаж холбогдох горим сорилыг хэрэгжүүлсэн болно.

Аудитын хязгаарлалт

Аймгийн хэмжээнд салбарын зээл, тусламжийн нэгдсэн мэдээлэл байхгүйгээс аудитын явцад ашиглах тооцоо судалгаа, нотлох болон дэмжих баримт материал хомс байсан тул хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын заавар аргачлалыг дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Д.Балжинням, Ц.Бадрал нар гүйцэтгэв.

Аудитыг 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 01-ний хугацаанд хэрэгжүүлж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, ҮАГ, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн цахим сайтад байршуулна.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Монгол Улс Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх" гэснийг үндэслэн хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна.

Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт Дэлхийн банкны 2, Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн 3, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 1, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын санхүүжилтээр нийт 276.6 сая ам.долларын төсөвт өртөгтэй хөнгөлөлтэй зээл болон буцалтгүй тусламжийн хэлбэрээр 12 төслийг Удирдах хороо болон төсөл хэрэгжүүлэх нэгжүүд хариуцан хэрэгжүүлсэн байна.

Азийн хөгжлийн банк Швейцарын хөгжлийн агентлаг, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын 2019 оны "Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээр", ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээг ХХААХҮЯ, 21 аймгийн 184 сумын ЗДТГ болон холбогдох бусад байгууллагууд 2016 оноос хойш хэрэгжүүлсэн байна.

Ховд аймагт зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох, "трактор", хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, "хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт" төслүүдэд аж ахуйн нэгж байгууллагууд хамруулан хэрэгжиж байна.

Дээрх зээл тусламжийн хүрээнд Ховд аймагт дараах төслүүд хэрэгжсэн байна. Үүнд:

- Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл / Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Алтай сум, Мянгад сум/
- "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт" төсөл / Монголиан Каттл ХХК/
- "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл" / мал эмнэлгийн газруудад тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах
- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл/ 7 төсөл/
- "Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл" / 3 аж ахуйн нэгж трактор тоног төхөөрөмж/ зэрэг төслүүд хэрэгжсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙГЭЭС ХЭРЭГЖИЛТИЙГ БОДИТТОЙ ДҮГНЭХ БОЛОМЖҮЙ БАЙНА

А.1. 1 Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан ч Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх V жилийн үндсэн чиглэлд зорилт, хүрэх түвшнийг нарийвчлан тусгаагүй байна.

А.1.1. "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бүсчилсэн хөгжил зорилтын хүрээнд Ховд аймгийг Монгол Алтай, Их нууруудын хотгорын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, өндөр уулын мал аж ахуй, Өрнө-Дорныг холбосон олон улсын тээвэр, логистик, аялал жуулчлал бүхий ногоон хөгжлийн бүс нутаг болгон хөгжүүлэхээр зорьж байна.

Зорилтын нэгдүгээр үе буюу 2020-2030 оны бүтээн байгуулалтын үеийн зорилтын хүрээнд Ховд аймагт бүс нутгийн онцлог, нүүдлийн мал аж ахуйд тохирсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, эрчимжсэн мал аж ахуй, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслүүд болон Эрдэнэбүрэн, Алтай сумуудад хүнсний ногооны усалгаатай ХАА-н төслүүд хэрэгжиж эхлээд байна.

Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал "Алсын хараа -2050", Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг урт болон дунд хугацааны бодлоготой уялдуулан Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулан Аймгийн ИТХ-ын хоёрдугаар хуралдааны тогтоолын хавсралтаар батлуулсан байна.

Хүснэгт -1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хамаарах заалтуудын харьцуулалт

Бодлого, хөтөлбөрийн нэр	Батлагдсан огноо	Хэрэгжих хугацаа	Гол агуулга, зорилтууд, хүрэх түвшин
"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	УИХ, 2020	2020-2050	- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна. - Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ - Уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурин орчимд бүсчлэн хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан, ногоон эдийн засгийн чиг баримжаатай мал аж ахуйг хөгжүүлнэ.
Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030	УИХ, 2016	2016-2030	- Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээг 2030 онд 60 хувьд хүргэх - Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх - Эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.

Монгол улсын 2021- 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	УИХ, 2020	2021- 2025	гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана - Монгол малын махны ач тусыг олон улсад сурталчлан таниулж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. - бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангана - малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ. - мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ. - мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.
Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	УИХ, 2015	2014- 2025	- ХАА-н ДНБ-ий 5 жилийн дундаж өсөлтийг 2020 онд 15, 2025 онд 20 хувьд хүргэх - Нийт төсөвт ХАА-н салбарын эзлэх хувийг 2020 онд 3, 2025 онд 4 хувьд хүргэх - Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг 2025 онд 200 мян.тн-д хүргэх - уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх
Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх V жилийн үндсэн чиглэл	ИТХ, 2020	2021- 2025	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангана. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ. ХАА үйлдвэрлэлийн нөөц ашиглалтын бүтээмжийг тооноос чанарт шилжүүлэх, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэхэд чиглэсэн Шинэ хөдөө цогц төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.

Монгол улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй харьцуулахад Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөрөнгийн эх үүсвэр, зарцуулагдах төсвийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг хэрэгжих онуудаар харуулаагүй, хариуцагч, оролцогч, хамтран ажиллах байгууллагууд нь тодорхойлоогүй, тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулаагүй, хэт ерөнхий төлөвлөсөн байна.

А.1.2 Монгол Улс Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх" гэснийг үндэслэн хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна.

Ховд аймагт 2016-2022 онуудын хугацаанд хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбарт 8 аж ахуйн нэгж 975,348 мянган төгрөгийн, 3 аж ахуйн нэгж 124,589 еврогийн зээл, тусламжийг авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт-2.Ховд аймагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын зээлийн мэдээлэл /мян.төг/

Д/д	Төсөл	Зээлдэгчийн нэр	Үндсэн үйл ажиллагааны төрөл	Олгосон зээл
1	Батлан даалтын хөрөнгө оруулалтын зээл	Булган номин уул ХХК	Үйлчилгээ	400.000
2		Голден Нетворк ХХК	Үйлдвэрлэл	4,320
3		Баясгалант өндөр хөхий ХХК	Үйлдвэрлэл	214,928

4		Г эрэлт манхан ХХК	Боловсруулах үйлдвэр	30,000
5		Мэргэн сонголт Пүү БГБХНөхөрлөл	Үйлдвэрлэл	61,200
6		Хишиг эрдэнэ баяжих ХХК	Үйлдвэрлэл	59,700
7		Сод мандал арвижих ХХК	Машин болон тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ	229,800
8	Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл	Монголиан Каттл ХХК	Эрчимжсэн МАА	375,000
НИЙТ ДҮН				975,348

Хүснэгт-3. Ховд аймагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын зээлийн мэдээлэл /евро /

Д/д	Төсөл	Зээлдэгчийн нэр	Үндсэн үйл ажиллагааны төрөл	Олгосон зээл
1	“Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”	Арвижих фарм	техник тоног төхөөрөмж	33,005
2		Булган эмээлт чулуу	техник тоног төхөөрөмж	23,744
3		Шинэ Ховд ББХК ААТҮГ	техник тоног төхөөрөмж	67,840
НИЙТ ДҮН				124.589

А.1.2 Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

А.1.3 ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс ЖДҮ-ийг дэмжих, газар тариалангийн бүтээгдэхүүн, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд зориулж хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг жил бүр олгогдож сүүлийн 5 жилд Ховд аймагт 2 орчим тэрбум төгрөгийн зээл, тусламжийг авч, салбарын зээл тусламжийн дийлэнх хэсгийг хөдөө аж ахуйн дэд салбарт буюу мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хэрэгжиж байна.

Илрүүлэлт:

- Аймгийн хэмжээнд салбарын зээл, тусламжийн нэгдсэн мэдээлэл байхгүйгээс аудитын явцад ашиглах тооцоо судалгаа, нотлох болон дэмжих баримт материал хомс байсан тул хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна. Цаашид мэдээллийн баазыг бий болгож бусад мэргэжлийн байгууллага, хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс ажлын тайлан мэдээг нэгтгэж ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн аудитын байгууллагаас хийгдэж буй аудиттай холбоотой мэдээллийг цаг тухай бүрд нь үнэн зөв, бодит мэдээллээр ханган ажиллах шаардлагатай байна.

А.2 Зээлийн хөрөнгийг ашиглагч зарим иргэн, аж ахуйн нэгж үр өгөөж бий болж байгаа ч зарим аж ахуйн нэгжүүд гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд бүрэн биелүүлээгүй байна.

А.2.1 Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт "Эцсийн зээлдэгч нь дараах нийтлэг үүрэгтэй", 31.3.1 дэх заалтад "Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу удирдаж ашиглах", 31.3.2 дахь заалтад "Дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх" гэж заасан байна. Зээлдэгчийн мэдээллийг төсөл тус бүрээр дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.

1.Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл:

Тухайн төслийн гол зорилго нь хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг зорилтот зах зээлд дээд зэргийн үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүнийг найдвартай нийлүүлэхийг дэмжих

замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн эдийн засгийн өсөлтийг дэмжихийг зорьсон. Төслийн эхний шатны хүрээнд дараах 2 гол үр дүнг гаргахаар ажилласан байна. Үүнд:

- Бусдаас ялгарах, дээд зэргийн үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүнийг зорилтот зах зээлд хүргэх чадамжтай нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх,
- Хамтын брэндийг хөгжүүлэх, удирдах процесс болон институтийн бүтэц зохион байгуулалт, журам, стандартыг бий болгох

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2016-2021 он хүртэл хэрэгжүүлж байна.

Хүснэгт -4

Д/д	Нэмүү өртөгийн сүлжээг хөгжүүлэх зээл	Зээлдэгчийн нэр	Салбар	Олгосон банк	Эхэлсэн огноо	Дуусах огноо	Нийт санхүүжилт	Гэрээний дагуу төлөх		Төлсөн		Нийт төлсөн	Үлдэгдэл
								хүү	нийт	хүү	ундсан		
1		Монголиан Каттл ХХК	Эрчимжсэн МАА	Голомт	2016.12.12	2023.12.02	375.0	112.9	487.9	67.4	328.1	395.5	92.4

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хоршоодын нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтыг дэмжихэд зориулан Монголиан Каттл ХХК-д "Мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр өргөжүүлэх төсөл"-өөр 2016 онд 7 жилийн хугацаатай 375.0 сая төгрөгийн зээлийг Голомт банкаар дамжуулан олгож, эргэн төлөлтийг гэрээнд заасны дагуу төлж, гэрээний үүргээ биелүүлэн ажиллаж байна.

2. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт

Тус төсөл нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилт авах боломж болон бизнесийн тогтвортой байдлыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлт болон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой хэрэгжиж байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2016 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу Азийн хөгжлийн банк нь Монгол Улсад дээрх зээлийн хэлэлцээрт тусгагдсан 60.0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийг барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын зээлийн батлан даалтад зориулах бөгөөд Зээлийн батлан даалтын сан нь энэхүү төслийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт -5. Батлан даалтын зээлийн мэдээлэл

Д/д	Зээлдэгчийн нэр	Салбар	Авсан зээл	Нэмэгдсэн ажлын байр	Гэрээний хэрэгжилт
1	Булганномин уул ХХК	Үйлчилгээ	400,000	20	хэвийн
2	Голден Нетворк ХХК	Үйлдвэрлэл	4,320	10	хаагдсан
3	Баясгалант өндөр хөхий ХХК	Үйлдвэрлэл	214,928	18	хаагдсан
4	Г эрэлт манхан ХХК	Боловсруулах үйлдвэр	30,000	8	хэвийн
5	Мэргэн сонголт Пүү БГБХНөхөрлөл	Үйлдвэрлэл	61,200	10	хэвийн
6	Хишиг эрдэнэ баяжих ХХК	Үйлдвэрлэл	59,700	5	хаагдсан
7	Содмандал арвижих ХХК	Машин болон тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ	229,800	8	хэвийн
НИЙТ ДҮН			600,348	79	

Төсөл хэрэгжүүлж буй 7 аж ахуйн нэгжүүд нь батлан даалтын хөрөнгө оруулалтын хүрээнд 600,348 мянган төгрөгийн зээлийг арилжааны банкнуудаар дамжуулан авч, 3 аж ахуйн нэгжийн 278,948 мянган төгрөгийн зээл хугацаадаа төлөгдөж дууссан, 4 аж ахуйн нэгжийн 321,400 мянган төгрөгийн зээл гэрээний хуваарийн дагуу эргэн төлөлт хийгдэж байна.

Тухайн зээлийн хөрөнгийг ашиглагч аж ахуйн нэгжүүд гэрээнд заасан үүрэг, зорилгоо биелүүлэн нийт 79 ажлын байр бий болгож, бизнесийн үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байна.

3.Бүгд найрамдах Беларусь улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл тусламжийн хүрээнд олгосон техник тоног төхөөрөмжийн төлөвлөсөн санхүүжилт төсөл

Хөдөө аж ахуйг дэмжих сантай трактор, хөдөө аж ахуйн техник худалдан, худалдан авах гэрээ байгуулан 3 аж ахуйн нэгж 124,589 еврогийн газар тариалангийн техник тоног төхөөрөмжийн зээл авч, зээлийн эргэж төлөгдөх төлбөр хугацаандаа төлөгдөхгүй он дамжих эрсдэл үүсэж, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Д/д	Төсөл	Зээлдэгчийн нэр	Үндсэн үйл ажиллагааны төрөл	Олгосон зээл	Эргэн төлөлт	Гэрээний үүргийн хэрэгжилт
1	"Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл"	Арвижих фарм	техник тоног төхөөрөмж	33005	0	төлөөгүй
2		Булган эмээл чулуу	техник тоног төхөөрөмж	23744	0	төлөөгүй
3		Шинэ Ховд ББХК ААТҮГ	техник тоног төхөөрөмж	67840	18775	төлөлт хийгдсэн боловч хуваариас дутуу төлөлттэй
НИЙТ ДҮН				124589		

А.2.2 Өрийн удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зорилго, нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашиг, эргэн төлөгдөх чадвараас нь хамааруулж эх үүсвэрийг дараах хэлбэрээр ашиглана", 24.1.2 дахь заалтад "Дамжуулан зээлдүүлэх", 24.1.3 дахь заалтад "Засгийн газар, яамд, тэдгээрийн харьяа байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх", 24.2 дэх хэсэгт "Нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх чиглэл баримтлах ба санхүүжүүлэх боломжгүй тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно" гэж заасны дагуу зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний ашиглалт дараах байдалтай байна.

- Монголиан Каттл ХХК "Мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр өргөжүүлэх төсөл"-өөр 2016 онд 7 жилийн хугацаатай 375 сая төгрөгийн зээл авч зориулалтын дагуу хөрөнгө оруулалтаа хийж үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлж жилд 90 орчим тонн мах бэлтгэдэг байсан бол төслийн зээлд хамрагдсанаар үйлдвэрийн хүчин чадлаа өргөтгөн 2022 онд 320 тонн мах, 70 тонн дайвар бүтээгдэхүүн боловсруулж, 2021 онд 140 тонн, 2022 онд 230.0 тонн махыг тус тус экспортод гаргасан байна. Түүнчлэн Ховд аймгийн малчдын мал махны борлуулалт нэмэгдэж мөнгөн орлого тодорхой хэмжээгээр нэмэгдсэн нь үр өгөөжтэй байна.
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилтийн төслөөс 7 ААН-д олгосон зээлийн үр дүнд тухайн зээлийн хөрөнгийг ашиглагч аж ахуйн нэгжүүд гэрээнд заасан үүрэг, зорилгоо биелүүлэн нийт 79 ажлын байр бий болгож, бизнесийн үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байна.

- Беларусь улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжсэн Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төслөөс 3 аж ахуйн нэгжид 4 трактор, 4 хадуур, 5 тармуур, 4 хаман боогч нийлүүлэгдсэнээр техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж сайжирч газар тариалангийн салбарт хөрс боловсруулах, ургац хураах зэрэгт тодорхой ахиц дэвшил гарч тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн ургацын хэмжээ нэмэгдсэнээр ашиг орлого тодорхой хувиар өссөн байна. Мөн хадлан өвс авах, өвсийг боох зэрэг үйл ажиллагаанд тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж зохих түвшинд нэмэгдсэн байна.
- Булган эмээ чулуу нөхөрлөл нь Беларусь улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр Беларусь-82.1, хадаар КДН-210, тармуур ГВР-630, ППТ-160 дөрвөлжин хаман боогч бүхий 33,920 еврогийн өртөгтэй тоног төхөөрөмжүүд авахаар БелТТ-21/112-12 тоот гэрээ байгуулсан ч техник төхөөрөмжөө авч чадаагүй гэсэн тайлбарыг 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр албан бичгээр ирүүлсэн тул дахин хянах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖСЭНЭЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРААС ОРОХ ОРЛОГО НЭМЭГДЭЖ ҮР ӨГӨӨЖ БИЙ БОЛОХООР БАЙНА

Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь салбарын бодлого, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Б.1.1 Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд гадаадын зээл тусламжаар энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг тусгасан байна. Зорилтын хүрээнд Ховд аймагт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр усалгааны системийн усны эх үүсвэрийг Ховд, Бодонч, Буянт, голуудаас авах ба усалгааг дуслын болон бороожуулах технологийг ашиглан Эрдэнэбүрэн, Алтай, Мянгад сумдад услалтын системийг шинээр барьж гүйцэтгэхээр туссан байгаа нь урт, дунд, богино хугацааны бодлоготой нийцэж байна.

Б.1.2 Услалтын системийг шинээр барьж байгуулснаар Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2019 оны суурь түшингээр усалгаатай газар тариалангийн талбай 2000 га байгааг, 2021-2025 онуудад усалгаатай газар тариалангийн талбайн өсөлтийг 5000 га-д хүргэхээр төлөвлөсөн ажил хэрэгжих мөн аймаг орон нутгийн эдийн засгийн өсөлт бий болох, газар тариалан эрхлэгчдийн орлого нэмэгдэх, ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зэрэг хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Б.1.3 Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журамд заасны дагуу гадаадын тусламжаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг сонгох, үнэлэх, эрэмбэлэх, шаардлагатай төсөл арга хэмжээний талаар аймгийн хэмжээнд холбогдох нотлох баримт, мэдээлэлгүй байна.

Б.2 Малын эрүүл мэндийн төсөл хэрэгжсэнээр бэлчээрийн менежментийг сайжруулахад тодорхой ахиц гарч, төсөл үр дүнтэй хэрэгжсэн байна. Харин услалтын системийг сайжруулах төслүүд гүйцэтгэлийн шатандаа явагдаж байна.

Б.2.1 Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл нь услалтын системүүдийг шинээр барих, сэргээн засварлах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах, борлуулалт, агуулахын дэмжлэг үзүүлэх замаар хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэн ногоочид, тариаланчдын чадавх, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулахаар Ховд аймагт хөдөө аж ахуйн салбарт гадаадын буцалтгүй тусламжаар доорх 2 төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

1.Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл:

- Алтай сумын Боомын амны услалтын системийг шинэчлэн сайжруулах 4,884.6 сая төгрөгийн өртөгтэй барилгын ажил гүйцэтгэх CW-1-1 тоот гэрээг “Агро-Альфа” ХХК-тай байгуулан 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт ажлын 40 орчим хувийг гүйцэтгэлтэй
- 2022 онд Эрдэнэбүрэн суманд 2000 га услалтын системийн барилгын ажил шинээр хийгдэхээр төлөвлөгдсөн, 2023 оны 7 дугаар сард 1000 га газар болгон өөрчилсөн, одоогоор ажил эхлээгүй,
- Ховд аймгийн Мянгад сумын Зараа толгойн услалтын системийн ажлыг нэмэлтээр баталсан, үйл ажиллагаа эхлээгүй зэрэг ажлын явцтай байна.

2.Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл:

- Мал эмнэлгийн салбарын эрт илрүүлэг, хариу арга хэмжээний туршилтын хөтөлбөрөөр 2021 онд сумдын 47 Мал эмнэлгийн нэгжүүдэд сургалт, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

Б.2.2 Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл нь бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, малчдыг зах зээл, засаглал, эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох боломжийг сайжруулах зорилгоор 2004-2016 онд 4 бүрэлдэхүүн, 2012-2016 онд малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах зорилгоор 3 бүрэлдэхүүн хэсэгтэйгээр Малын эрүүл мэнд (МЭМ) төслийг тус тус хэрэгжиж, төслийн үр дүнг 2021 оны 8 сарын 17-нд орон нутагт хүлээлгэн өгсөн байна.

Ногоон алт малын эрүүл мэнд төслийн хүрээнд анх 2008 онд Дуут, Манхан сумдад сумын бэлчээр ашиглагчдын холбоо, 2009-2012 онд 13 суманд ХАА-н хоршоо болон дундын хоршоо байгуулагдан, 2018-2019 онд 7 суманд Хадгаламж зээлийн хоршоотой болж, сумдын 7600 малчин ТББ-д гишүүнчлэлд хамрагдан аймаг, сумдын 80 гаруй бэлчээр ашиглагчдын холбоо байгуулагдсан байна. Дээрх хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжүүдийг сумдын бэлчээр ашиглагчдын холбоод эзэмшиж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТАГТ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БАЙХГҮЙГЭЭС ҮР ДҮНГ ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

В.1 Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан ч орон нутгийн зүгээс төсөл, арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна.

В.1.1 Төслийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаарх явцын болон үр дүнгийн мэдээллийг орон нутгийн телевиз, аймгийн Засаг даргын тамгын газрын албан ёсны вэб сайт, Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацын фэйсбүүк хуудаст байршуулан иргэд олон нийтэд сурталчилж ажилласан байна.

"Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд Мал эмнэлгийн газарт 193.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгснийг шилэн дансны нэгдсэн системд мэдээлсэн байна. Харин "Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл" /зээл/-д орон нутгийн өмчит үйлдвэрийн газар хамрагдсан бөгөөд энэ талаар шилэн дансны нэгдсэн системд мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1¹, 3.2.6², 6.4³, 6.4.8⁴, 6.3⁵, 6.3.5⁶, 6.5⁷, 6.5.2⁸, 7.1⁹, 7.1.1¹⁰ дэх заалттай нийцээгүй байна.

В.1.2. Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн арга хэмжээнд хяналт шалгалт хэрэгжүүлээгүй байна.

В.1.3. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас ажлын хэсэг 2023 онд Ховд аймагт ирж ажилласан ч түүнтэй холбоотой тайлан, мэдээлэл байхгүй байна. Харин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2016-2022 онуудад хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдэж албан ёсны цахим хуудсанд тайлангуудыг байршуулснаас харахад хяналт хэрэгжүүлж байгаа боловч орон нутгийн захиргааны байгууллага, Хүнс, хөдөө аж ахуйн газруудад төслийн хэрэгжилтийн явц, хяналтын талаар мэдээлэлгүй байна.

¹ Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна"

² "Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж"

³ "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ",

⁴ заалтад "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр",

⁵ "Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна",

⁶ "хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт",

⁷ "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана",

⁸ "Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр",

⁹ "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ",

¹⁰ "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан"

Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх ажил Сангийн сайдын баталсан журмын хүрээнд хэрэгжихээр батлагдсан боловч уг журмаар орон нутагт зээлийн хүрээнд хэрэгжиж буй ТАХ түүний гүйцэтгэл, үр дүнд хяналт тавих эрх зүйн нөхцөл боломж бүрдээгүйгээс зээлийн хэрэгжилт үр дүнг тооцох боломжгүй байна.

В.2. Хөдөө аж ахуйн зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

В.2.1 Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 25.6-д “Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төслийн эцсийн тайланг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн эцсийн тайлангийн загвар” маягтын дагуу боловсруулж, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, Удирдлагын мэдээллийн системд оруулсан бөгөөд төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлнэ” гэж заасны дагуу тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгүүдийг бүртгэж байна. Үүнд:

- Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөр аймгийн мал эмнэлгийн газрын хэрэгцээнд зориулж 4.0 сая төгрөгийн 55 инчийн TV (зөөврийн хөлийн хамт), Видео хурлын камер, Видео хурлын системийн чанга яригчтай микрофон, мал эмнэлгийн лабораторид малын гоц халдварт өвчнийг оношлох чадавхыг сайжруулахад нь зориулж Бодит хугацааны ПГУ-ын машин, Биоаюулгүй байдлын II зэрэглэлийн кабинет, Эйр кондишн, Аюулгүйн шүршүүр, нүд угаагч, -86 хэмийн гүн хөлдөөгч зэрэг 189.4 сая төгрөгийн лабораторийн зориулалттай 5 нэр төрлийн, 11 ширхэг багаж, тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авч бүртгэсэн,
- Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд ашиглагдаж байсан байр, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг сумын болон аймгийн “Бэлчээр ашиглагчдын холбоо” ТББ-ын хамтын өмчлөлд бүртгэсэн тухай, төсөл дууссанаас хойш дээрх хөрөнгийг хамтран ашиглах талаар Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 31/2020 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. Иймээс төрийн байгууллагын хөрөнгөд дээрх хөрөнгийг бүртгээгүй байна.

Аудитаар нийт 187.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 187.8 сая төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар аймгийн Засаг дарга, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацийн даргад өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ОРОН НУТАГТ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БАЙХГҮЙГЭЭС ҮР ДҮНГ ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын багт уламжлах дараах асуудлууд байна Үүнд:

1. Беларусь улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр Булган эмээл чулуу нөхөрлөлд ХАА-н техник хэрэгсэл олгогдоогүй гэсэн тайлбар ирүүлсэн тул нотлох баримтуудтай тулган шалгах,
2. Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд ашиглагдаж байсан байр, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг сумын болон аймгийн "Бэлчээр ашиглагчдын холбоо" ТББ-ын хамтын өмчлөлд бүртгэгдэж байгаа асуудлыг улсын хэмжээнд нэгдсэн зөвлөмж өгч хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх,

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ :

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Э.БОЛОРМАА ТАНАА

- Ховд аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан төлөвлөх
- Аймгийн хэмжээнд салбарын зээл, тусламжийн нэгдсэн мэдээлэл сан, тооцоо, судалгааг тухайн он бүрээр бүрдүүлэх

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТЦЭНГЭЛ ТАНАА

- Гэрээнд заасны дагуу зээлийн гэрээний хэрэгжилтийг ханган талаар тодорхой арга хэмжээ авах

ШИНЭ ХОВД БАРУУН БҮСИЙН ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ ААТҮГ-ИЙН ДАРГА Ш.БАТЖАРГАЛ ТАНАА

- Шилэн дансны тухай хуулийн заалтуудыг мөрдөн, холбогдох мэдээллийг бүрэн байршуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцон 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх.